



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/393

Улаанбаатар хот


Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4 болон Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн "Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай" 151 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны нэр өөрчлөгдөж, Холбоо навигаци, ажиглалтын алба болсонтой холбогдуулан хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Захиргаа, удирдлагын газар /Т.Батжаргал/, Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Ё.Эрдэнэбат/-т тус тус үүрэг болгосугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны "Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/827 дугаар тушаалд өөрчлөлт орсонд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН